



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555
И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.08.26 № 01/1686

танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДҮҮДЭД**

Тус компаниас 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зарласан ЭТТХК/20240102296 дугаартай XCMG маркийн техник, автомашины сэлбэг эд анги нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг тендер оролцогчоос гаргасны дагуу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж, 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 01/1126 дугаартай “Тендерийн баримт бичиг хянасан тухай” ирүүлсэн албан бичгийн дагуу тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

ТШЗ-ны холбогдох заалт	В. ТЕНДЕР БЭЛТГЭХ		
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцтай		
	Багцын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Багцын дугаар
	Багц 1.	XCMG маркийн техникүүдийн техник үйлчилгээний материал	ЭТТХК/20240102296-1
	Багц 2.	XCMG 4531K чингэлэг ачигчийн сэлбэг, эд анги	ЭТТХК/20240102296-2
	Багц 3.	XCMG-GR230 автогрейдрийн сэлбэг, эд анги	ЭТТХК/20240102296-3
	Багц 4.	Бусад	ЭТТХК/20240102296-4
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: “Тийм” Багц 1: XCMG маркийн техникийн техник үйлчилгээний материал Дотоодод үйлдвэрлэсэн болохыг нотлох баримт бичгийг ирүүлнэ.		
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 477,951,540 (дөрвөн зуун далан долоон сая есөн зуун тавин нэгэн мянга таван зуун дөч) төгрөг		
	Багцын дугаар	Төсөвт өртөг /төгрөг/	Төсөвт өртөг /үсгээр/
	Багц 1.	47,474,300	Дөчин долоон сая дөрвөн зуун далан дөрвөн мянга гурван зуу
	Багц 2.	396,282,348	Гурван зуун ерэн зургаан сая хоёр зуун наян хоёр мянга гурван зуун дөчин найм
	Багц 3	15,504,500	Арван таван сая таван зуун дөрвөн мянга таван зуу
	Багц 4.	18,690,392	Худалдан авалт хийхгүй
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: “Шаардана”		
	Багцын дугаар	Баталгааны дүн /Мөнгөн дүнгээр/	Баталгааны дүн /Үсгээр/

1124043089

	Багц 2	1,981,412	Нэг сая есөн зуун наян нэгэн мянга дөрвөн зуун арван хоёр
Хүчинтэй байх хугацаа: Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байна.			
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ			
ТШЗ 24.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.		
ТШЗ 26.1.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Цаг: 10 цаг 10 минут Тендер нээх газрын хаяг: “Эрдэнэс Таван толгой” ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, 5-р давхар, 502 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс		

Хавсралтаар өөрчлөлт орсон тендерийн баримт бичгийг хүргүүлж байна.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 10.3-т заасны дагуу дээрх нэмэлт өөрчлөлтүүд нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ